

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх ажил/арга хэмжээ		Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн	Биелэлт
1.	-Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл /2014 он/, -Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2012-2016 он/, -2014 онд УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлж, батлуулахаар тусгасан хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл	Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөлд ХАХНХЯ-наас зохион байгуулсан чуулгануудад оролцсон иргэдийн саналын дагуу гаргасан зөвлөмж, бодлогын баримт бичгийн төслийн талаар вэб хуудсаар болон иргэний танхимаар хэлэлцүүлж гаргасан саналуудыг тусгах	2014 оны Хаврын чуулган	Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар	<p>Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл нь үндэсний хэмжээний болон хэсэгчилсэн олон удаагийн зөвлөлдөх уулзалтын үр дүн гэж үзэж болно. Бодлогын төсөлд ХАХНХЯ-наас зохион байгуулсан чуулгануудад оролцсон иргэдийн саналын дагуу гаргасан зөвлөмж, вэб хуудсаар ирсэн санал, иргэний танхимаар хэлэлцүүлж гаргасан саналуудыг тусгасан ба тэдгээр санал, зөвлөмжийн үзэл санаа бүхэлдээ шингэсэн болно.</p> <p>Бодлогын баримт бичгийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, гишүүдийн саналыг тусган, УИХ-д өргөн бариад байна.</p>
		Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэдээс вэб хуудсаар болон сонирхогч бүлгээс ирүүлсэн саналыг тусгах	2014 оны Намрын чуулган	Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Нийгмийн даатгалын алба	<p>Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төслийг боловсруулахдаа нийгмийн даатгалын хуулиудыг хэрэгжүүлэх явцад нийтлэг гардаг зөрчил, давхардалыг арилгахаар аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн саналд үндэслэж боловсруулав. Хуулийн төслийг Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 24-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, 2014 оны 9 дүгээр сарын 04-ны өдөр УИХ-д өргөн барив.</p>
		Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийн төслийн талаар иргэдээс вэб хуудсаар санал авч тусгах	2014 оны Намрын чуулган	Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	<p>Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар ажлын хэсгийг байгуулан, мөн Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны хөтөлбөрийн хүрээнд олон улсын болон үндэсний зөвлөхүүдтэй хамтран ажиллаж Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын төслийг боловсруулан Засгийн газрын 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, үзэл баримтлалын төслийг Хууль зүйн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд хамтарч батлав. Тус бодлогын төслийн 5.1.4.Тэтгэврийн даатгалын сангийн ирээдүйн болзошгүй алдагдал, тэтгэврийн шинэчлэлийн шилжилтийн</p>

					арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор тэтгэврийн нөөц сан байгуулах тухай заалт тусгагдсан. энэхүү заалт нь ашигт малтмал болон байгалийн баялгаас хуримтлуулах сангаас тэтгэврийн даатгалын сангийн орлогоороо зарлагаа нөхөж чадахгүй болох зэрэг эрсдлийг нөхөх зорилготой юм. Бодлогын төслийг холбогдох яамдууд, үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын нэгдсэн холбоод зэрэг түншлэгч байгууллагуудаас санал авч нэгтгээд Засгийн газрын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 1/2117 тоот албан бичгээр хүргүүлээд байна.
		Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төслийн талаар иргэдээс веб хуудсаар санал авч тусгах	2014 оны Намрын чуулган	Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төсөлд бүх яамд, ажил олгогч даатгуулагчдын төлөөллөөс саналыг авч, үзэл баримтлалыг батлуулан УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьсан.
		Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг сонирхогч бүлэг, олон нийтээр веб хуудсаар хэлэлцүүлэх	2014 оны Намрын чуулган	Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд яам, агентлаг, ТББ, иргэдийн 93 санал ирсэнээс 79 саналыг тусгаж, төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна
		Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэдээс веб хуудсаар санал авч тусгах		Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд яамд, ТББ, иргэдээс санал авч тусган төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, УИХ-д өргөн бариад байна.
2.	Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах	2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг АТГ-д хүргүүлэх	2014.02.28 -ний дотор	ЭБАТ Э.Ариуннаран	2014.02.25-ны өдрийн 3/357 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлсэн.
		Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах	Жилдээ	ЭБАТ Э.Ариуннаран	Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж АТГ-т хүргүүлсэн.
		Тайлан, нотлох баримтыг хүргүүлэх	2014.11.15	ЭБАТ Э.Ариуннаран	Тайлан нотлох баримтуудыг хүргүүлэв.
3.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах	Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар газар, хэлтсийн дарга нар т мэдээлэл хийх	2014.04.07,	Хуулийн дарга, Авлигатай тэмцэх газар	Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар газар, хэлтсийн дарга нар болон мэргэжилтнүүдийг оролцуулан АТГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран 2014.10.14-ний өдөр сургалт зохион байгуулсан.
		Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар мэргэжилтнүүдэд мэдээлэл хийх	2014.08.15	Хуулийн дарга, Авлигатай тэмцэх газар	
4.	Салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ		2014.03.07	Хуулийн хэлтэс,	Нийтээр дагаж мөрдөх болон салбарын хэмжээнд иргэдэд

	тогтоосон шийдвэрийг цахим хуудсанд байршуулах, жагсаалтыг АТГ-т хүргүүлэх /хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх дүрэм, журмыг нэрээр нь байршуулах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх/	-ны дотор	Мэдээллийн технологи, вэб хуудас хариуцсан мэргэжилтэн Э.Баттулга нар, Хууль сурталчлах албаны ажилтан О.Номин-Эрдэнэ	үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжуудыг цахим хуудсанд байршуулсан. Мөн салбарын хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой иргэдээс ирүүлдэг түгээмэл асуултуудад хариулт бэлтгэн хууль тогтоомжуудыг сурталчилж байна. 2014 онд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон сайдын 1 тушаалыг хууль зүйн яаманд хянуулан legalinfo.mn болон байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	
5.	ХАХНХЯ-ны хяналт шинжилгээ, үнэлгээ	Үр дүнгийн гэрээ, дотоод ажлын хяналт	2014.1.2-10	ХШУДАГ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны харъя агентлаг болон төсвийн ерөнхийлөн захирагч нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд үнэлгээ хийсэн
		Нийгмийн даатгалын ерөнхий газар – Журмын биелэлт	2014.01.13-24	ХШУДАГ	Нийгмийн даатгалын ерөнхий газрын журмын биелэлт хяналт шинжилгээ, үнэлгээг хийв
		ХТҮГ – Хүүхэд, хөгжил, хамгааллын төв	2014.01.27-02.14	ХШУДАГ	Хүүхдийн төлөө үндэсний газрын харьяа Хүүхдийн хөгжил, хамгааллын төвийн үйл ажиллагаанд 2014 оны 1 дүгээр сарын 20-ноос эхлэн ажлын 3 өдөрт дотоод аудит хийлээ. Хүн амын хөгжлийн бодлогын шинэчлэлийн хүрээнд хүүхдийн асрамж, халамж, хамгааллыг хувилбарт хэлбэрээр цогц хүргэх төрийн үйлчилгээний оновчтой хэлбэрийг Хүүхдийн хөгжил, хамгааллын төвд нэвтрүүлж, үйлчилгээний зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж, үр дүнтэй зохион байгуулах гэсэн аудитын дүгнэлт гарсан. 2014 оны 3-р сард Хүүхэд, гэр бүл хөгжлийн Өнөрбүл төвд харьяалуулсан.
		НХҮЕГ – Ахмадын амралт, сувиллын үйлчилгээ	2014.02.17-03.07	ХШУДАГ	НХҮЕГ – Ахмадын амралт, сувиллын үйлчилгээг хийв.
		НХҮЕГ – төсөл, үйл ажиллагаа	2014.03.10-03.21	ХШУДАГ	Хугацаа хойшлогдсон
		НХҮЕГ – Халамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж байгаа ажил	2014.04.01-11	ХШУДАГ	Хугацаа хойшлогдсон
		НДЕГ – Нийгмийн даатгалын сан	2014.04.14-25	ХШУДАГ	Хугацаа хойшлогдсон
		ХТҮГ – ОУ-ын Найрамдал төв	2014.05.01-09	ХШУДАГ	Хүүхдийн төлөө үндэсний газар, олон улсын Найрамдал төвийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг хийв.
		Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээ	2014.06.15-27 2014.12.14-26	ХШУДАГ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын төсвийн ерөнхийлөн захирагчтай 2013 онд байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ бүх аймгийн Засаг дарга нар зохих түвшинд биелүүлсэн гэж дүгнэсэн. Эдгээр гэрээний биелэлтэд Засгийн

					<p>газрын 2013 оны 322-р тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ын дагуу тухайн жилийн гэрээний биелэлтийн тайланд үнэлгээ өглөө. Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2013 онд байгуулсан хөтөлбөр, төслийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан гэрээний биелэлтийн тайланг 4 хөтөлбөр тус бүрээр нь аймгууд гаргаж өгсөн бөгөөд 12 аймгийн Засаг даргын биелэлт 90 хувиас дээш хувь 4,548-5,000, 6 аймгийн Засаг даргын хувьд 81,98-89,61 хувь буюу 4,099-4,480, 3 аймгийн Засаг даргын хувьд 68,84-78,56 хувь буюу 3,928-3,442 гэсэн үнэлгээтэй байна.</p> <p>2014 оны биелэлтийн тайланг одоогоор ирүүлээгүй байгаа.</p>
	Орон нутгийн ХАХНХ-ын салбарын ажиллагаа	үйл үйл	2014.05.12-23 2014.08.03-22	ХШУДАГ	Орон нутгийн агентлаг болох Сэлэнгэ аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсүүдийн үйл ажиллагаан хяналт шинжилгээ хийсэн болно.
	Яамны худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа		2014.09.01-19	ХШУДАГ	Сангийн яамтай хамтран 2014 оны 9 дүгээр сарын 01-нээс ажлын 15 хоногт Яамны худалдан авах үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн. Тайланг Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газарт өгсөн.
	ХАХНХЯ – СБТГ, СХОХ		2014.10.01-17	ХШУДАГ	Хугацаа хойшлогдсон
	СЗХҮТ		2014.10.27-11.14	ХШУДАГ	Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв нь хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургалт, судалгаа хийх, тусламж үйлчилгээг цогцоор нь чанартай, хүртээмжтэй хүргэх үүрэг бүхий яамны харьяа байгууллага юм. 2014 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс ажлын 7 хоногт багтаан 2 аудит хийсэн. Тус төвд хийсэн дотоод аудитын шалгалтаар нийт 12 зөрчил дутагдал илэрсэн. 2014 оны 10 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд гаргасан зөрчил дутагдлаа залруулсан эсэхийг шалгаж, Сайдын зөвлөлийн хурлаар оруулсан.
	НДЕГ – Нийгмийн даатгалын шимтгэл		2014.11.16-12.05	ХШУДАГ	Хугацаа болоогүй

Санамж:

- Тухайн жилд явуулах хяналт шинжилгээний жагсаалтыг гаргаж АТГ-д ирүүлэх /яамны 2014 оны төлөвлөгөөнд тусгасан бол түүнийг хуулбарлан ирүүлж болох/, тухайн жилд хяналт шинжилгээг төлөвлөөгүй бол жилийн эцэст энэ талаар тайланд тусгайх ёстойг анхаарах. Төлөвлөгөөт бус хяналт шинжилгээний талаар мэдээллийг мөн нэгэн адил нээлттэй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авах ёстойг анхаарах
- Дээрх арга хэмжээг вебсайтад байршуулсан байдлаар үнэлэхийг анхаарах

6.	Төсвийн орлого, түүний	ХАХНХЯ-ны 2014 оны төсөв	2014.01.10	Санхүү, хөрөнгө	ХАХНХЯ-ны 2014 оны төсвийг байгууллагын цахим хуудсанд
----	------------------------	--------------------------	------------	-----------------	--------------------------------------------------------

зарцуулалтыг, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг вебсайтад байршуулах		-ны дотор	оруулалтын хэлтэс	байршуулсан
	2013 оны төсвийн гүйцэтгэл	2014.04.25 -ны дотор	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хууль"-аар төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн гаргалаа. 2013 оны гүйцэтгэлээр нэгтсэн төсвийн нийт орлогын бүрдүүлэлт 123.2 хувийн биелэлттэй, нийт төсвийн зарлага 97.3 хувийн биелэлттэй гарч тайлангийн хугацаанд 2,2 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулахаас 2,6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн Харин төсвийн урсгал үйл ажиллагаанд 369.1 тэрбум төгрөг зарцуулахаас 359.1 тэрбум төгрөг зарцуулсан бол "Хүний хөгжлийн сангийн тухай хууль"-аар олгож буй хүүхэд гэр бүлийн хөгжилд зориулан 1,2 сая иргэнд 257,1 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтанд 8.7 тэрбум төгрөг тус тус зарцуулсан болно. Тусгай сангуудын сар бүрийн мэдээ, Санхүүгийн үйл ажиллагааны хагас болон жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланг бүрэн эхээр нь яамны вэб сайтад тогтмол тавигдаж олон нийтэд нээлттэй ил тод байдлыг эрхэмлэн ажиллаж байгаа болно
	2015 оны төсвийн төсөл	2014.08.20 -ны дотор	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	2015 оны төсвийн төслийг цахим хуудсанд байршуулсан болно.
	2013 оны санхүүгийн тайлан	2014.04.25 -ны дотор	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Сайдын багцын 2013 оны аудитлагдсан санхүүгийн нэгдсэн тайланг бүрэн эхээр нь яамны веб сайтад байршуулсан байгаа болно.
	2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт		Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Зөрчилгүй санал дүгнэлт Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн төлөв байдал, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг УСННБОУС-д нийцүүлж Сангийн сайдын тушаалаар баталсан төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журам, аргачлалын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна. ҮАГ-ын дүгнэлтийг бүрэн эхээр нь вэб сайтад байрлуулсан болно.
	2014 оны төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл	өөрчлөлт орсноос хойш 14 хоног	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	2014 оны төсөвт өөрчлөлтийн ороогүй болно.
	Төсвийн орлого	2014.04.25	Санхүү, хөрөнгө	ОУХНТөвөөс 2,4 тэрбум, ХТҮГазраас 2,6 сая, НХҮЕГ-аас 0,2

	бүрдүүлэлтийн талаарх 2013 оны мэдээлэл /татварын, татварын бус/	-ны дотор	оруулалтын хэлтэс	сая, орон нутгийн НХҮХ-с 133,4 сая, СЗҮТ-с 135,1 сая, халамжийн сангаас 57,4 сая бүгд 2,7 тэрбум
	Концессийн зүйлийн жагсаалт, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, гэрээний талаарх мэдээлэл	Батлагдса наас хойш 14 өдрийн дотор	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан шаардлагын дагуу мэдээлэх, вебсайтад байршуулах
	Нийгмийн даатгалын сангийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нийтэд зарлах, вебсайтад байршуулах		Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	Нийгмийн даатгалын сангийн тухай хуулийн хүрээнд 2012 оны тусгай сангийн тайланг 5 сангаар нь төсвийн гүйцэтгэлийг веб сайтад байршуулсан байга болно
	2014 онд нийгмийн даатгалын сангаас тэт-гэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг вебсайтад байршуулах	1 дүгээр улиралд	Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	Хүн амд үзүүлж буй нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой гарын авлагууд, асуулт хариултуудын талаарх мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулсан. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг гарган байршуулах ажлыг НДЕГ газар хариуцан гүйцэтгэж байгаа болно.
	2014 онд гадаадын зээл, тусламжаар хэрэгжих болон хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр жагсаалтыг гаргаж АТГ-д ирүүлэх	2014.03.01 -ний дотор	ХАХБХЗГ, НХБХЗГ, ХШУДАГ, СБТГ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд "Ядуу иргэдийг илүү сайн хамгаалах чиглэлээр засгийн газарт дэмжлэг үзүүлэх" төсөл, "Хүн амын асуудлыг ядууруултай уялдуулах" төсөл, "Жендэрийн тэгш байдлыг хангах" Үндэсний хөтөлбөр, "Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих" Үндэсний хөтөлбөр, "Өрхийн хөгжлийг дэмжих" Үндэсний хөтөлбөр, "Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах" Үндэсний хөтөлбөр зэрэг хэрэгжиж байна.
	Дээрх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг вебсайтад байршуулах	Тухай бүр	ХАХБХЗГ, НХБХЗГ, ХШУДАГ, СБТГ	Дээрх төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байгууллагын цахим хуудсанд байршуулсан болно.
	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын Сайдын багцын 2013 оны III улирлын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн гүйцэтгэлийг нийтэд зарлах, вебсайтад байршуулах	2014.04.25 -ны дотор	ХШУДАГ, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Яамны цахим хуудсанд он тус бүрээр тайланг байршуулсан.
	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын Сайдын төсвийн	2014.04.25 -ны дотор	ХШУДАГ, Санхүү, хөрөнгө	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын Сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг цахим


		багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нийтэд зарлах, вебсайтад байршуулах		оруулалтын хэлтэс	хуудсанд байршуулсан болно.
		Нийгмийн даатгалын сангийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нийтэд зарлах, вебсайтад байршуулах	2014.04.25 -ны дотор	ХШУДАГ, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Нийгмийн даатгалын сангийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг цахим хуудсанд байршуулсан болно
		Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайланг нийтэд зарлах, вебсайтад байршуулах	2014.04.25 -ны дотор	ХШУДАГ, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Яамны цахим хуудсанд он тус бүрээр тайланг байршуулсан.
Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг байхгүй болно					
7.	Хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангах	Яамны ажлын байрны мэдээллийг вебсайтад байршуулах, төрийн албаны салбарын зөвлөлөөс зарлагдах сул орон тооны байрыг нөхөх төрийн албан хаагчийн шалгалтын зарлалыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	Тухай бүр	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Э.Энхзаяа, мэргэжилтэн Ж.Амаржингуа	2014 онд Төрийн жинхэнэ албан тушаалын 6 сул ажлын байранд Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллаа. Сонгон шалгаруулалтын зарыг Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журамд заасны дагуу сонгон шалгаруулалт явуулахаас 21 хоногийн өмнө Төрийн албаны зөвлөлийн вэб сайт www.csc.mn , Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны вэб сайт www.hun.gov.mn сайтууд болон “Зууны мэдээ” сонинд нээлттэй, ил тод байдлаар зарлаж ажилладаг.
		Тайлант хугацаанд томилогдсон албан тушаалтны жагсаалт, ажил үүргийн чиглэлийн жагсаалт гаргаж АТГ-д ирүүлэх	2014.11.15	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн Ж.Амаржингуа	<ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн чадавхи хариуцсан мэргэжилтэн • НҮБ, олон талт гэрээ, эрхзүйн асуудал хариуцсан мэргэжилтэн • Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жендэрийн асуудал хариуцсан хуулийн мэргэжилтэн • Нийгмийн хамгааллын асуудал хариуцсан хуулийн мэргэжилтэн • Нийгмийн даатгалын бодлого төлөвлөлт, хэтийн тооцоолол хариуцсан мэргэжилтэн • Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтсийн дарга • ХБИ-ийн сэргээн засах үйлчилгээний бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ, хөгжлийн бодлого, зохицуулалт хариуцсан

					<p>мэргэжилтэн бөгөөд Дэд сайдын туслах</p> <ul style="list-style-type: none"> • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хамгаалал, бүртгэл, мэдээлэл бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн • Нийгмийн даатгалын бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн • Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын бодлогын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн • Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн
		Хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шаардлагыг хангах	2014.01.15	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	<p>Албан хаагчидтай хамааралтай мэдээлэл, тушаал, судалгаа зэргийг яамны вэб сайт болон яамны мэдээллийн самбар, дотоод сүлжээ spark-т байршуулж, албан хаагчдад цаг алдадгүй мэдээллийг дамжуулан ажиллаж байна. Тус яамны ажилтан албан хаагчдын дунд байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг авч эхлэх бэлтгэл ажлыг хангаад байна. Нэгдсэн дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр зохион байгуулах шаардлагатай ажлын жагсаалтыг гарган хүний нөөцийн стратеги төлөвлөлтөнд тусгахаар ажиллаж байна.</p> <p>Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратегийг шинээр боловсруулахаар Дэлхийн банкнаас зөвлөх аван ажиллаж байна.</p>
8.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	Худалдан авах ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг нийтэд зарлах, вэбсайтад байршуулах	2014.01.01	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	2013.11.18 ны өдөр тутмын сонинд нийтэлсэн. Яамны цахим хуудсанд байршуулсан.
		Худалдан авах ажиллагааны 2015 оны төлөв-лөгөөг нийтэд зарлах, вэбсайтад байршуулах	2014.12.15	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	
9.	Төрийн албан хаагч нэг бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийн нээлттэй байдлыг хангах, вэбсайтад байгаа мэдээлэлд зохих өөрчлөлт оруулах	Тухай бүр	Төрийн захиргааны удирдлагын газар, Захиргаа хүний нөөцийн хэлтсийн мэргэжилтэн Ж.Амаржингуа	Тус яамны албан хаагч бүрийн хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг яамны www.hun.gov.mn сайтад байршуулаж ажиллаж байна. Шинээр албан хаагч томилогдох болон, чөлөөлөгдөх тохиолдолд вэб сайтад байршсан мэдээлэлд өөрчлөлтийг тогтмол хийж байна.	
10.	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөний	Тухай бүр	ТЗУГ, СБТГ, НХБХЗГ,	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөний дэмжих, үйл	

	дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах /сонгон шалгаруулалтын үр дүнд үндэслэн зарим үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх /ямар арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх талаар тодорхой тусгах/		ХАХБХЗГ, ХШУДАГ	ажиллагаандаа татан оролцуулаагүй болно.	
11.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	Дүрмийн төслийг боловсруулж АТГ-аас санал авах	2014.04.18	ЭБАТ Э.Ариуннаран	Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа "Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг мөрдөн ажиллаж байна.
		Дүрмийг батлах, нийт албан хаагчдад танилцуулах	2014.06.01	ЭБАТ Э.Ариуннаран	
		Хэрэгжилтэд хяналт тавих, энэ талаар АТГ-т тайлагнах	2014.11.15	ЭБАТ Э.Ариуннаран	
12.	Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтын дагуу яамны албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн байдлын судалгааг гаргаж, АТГ-д тайлагнах	Тухай бүр	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Сэргэлэн	Хууль тогтоомжийн дагуу үнсэн ажил үүргээс гадна дараах 3 албан тушаалтан давхар ажил эрхэлж байна. 1. Хуулийн хэлтсийн мэргэжилтэн нь авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцаж байна. 2. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга нь Нууцын ажилтаны ажил үүргийг хариуцаж байна. 3. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн нь дайчилгааны төлөвлөгөөтэй холбоотой асуудлыг хариуцаж байна.	
13.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал /нууцад хамааруулснаас бусад/-ыг цахим хуудсанд байршуулах	Тухай бүр	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Архивын ахлах ахлах мэргэжилтэн Д.Байгалмаа	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалуудыг жилийн эцсийн байдлаар нууцад хамаарах эсэхийг ангилж, цахим хуудсанд байршуулах болно.	
14.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах /уг арга хэмжээнд олон нийтийг татан оролцуулах, тодорхой судалгаа шинжилгээний үндсэн дээр тулгуурлах/	1-р улиралд	ЭБАТ Э.Ариуннаран	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргасан. /Хавсаргав/
		Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны ажиллагааг хянах нөхцөл боломжийг бүрдүүлэх	2-р улиралд	ЭБАТ Э.Ариуннаран	Эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээг гүйцэтгэх албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааг ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг бөглүүлэн хяналт тавьж ажиллаж байна.
15.	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар АТГ-т мэдээлэх	Тухай бүр нэн даруй	Зохион байгуулалтын бүтцийн нэгж,	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудал илрээгүй болно.	

16.	Авлигатай тэмцэх газраас эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмж	Тухай бүр	мэргэжилтэн Зохион байгуулалтын бүтцийн нэгж, мэргэжилтэн	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж, хариуг албан бичгээр хүргүүлсэн болно.
		АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдэл	Тухай бүр	Зохион байгуулалтын бүтцийн нэгж, мэргэжилтэн	АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар мэдэгдэл ирүүлээгүй болно.
		Зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичиг	Тухай бүр	Зохион байгуулалтын бүтцийн нэгж, мэргэжилтэн	Зөрчил арилгуулахаар албан бичиг ирүүлээгүй болно.
		Хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичиг	Тухай бүр	Зохион байгуулалтын бүтцийн нэгж, мэргэжилтэн	Арга хэмжээ авахуулахаар албан бичиг ирүүлээгүй болно.
		Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох	Тухай бүр	Зохион байгуулалтын бүтцийн нэгж, мэргэжилтэн	Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, заавар, шийдвэр байхгүй болно.
		АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ын хэрэгжилт	Тухай бүр	Зохион байгуулалтын бүтцийн нэгж, мэргэжилтэн	Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэл байхгүй болно.

Төлөвлөгөөний биелэлт гаргасан: Хуулийн хэлтсийн мэргэжилтэн



Э.Ундраа